



## Монголын Үйлдвэрлэлийн Хөгжлийн Төлөө



### Энэ дугаарт:

№. 2 / 2017

- Ажилчдыг сургаж, мэргэшүүлэх нь
- ВРN-ийн Монгол зөвлөлтэй хамтарсан сургалт
- Ирэх сургалтуудын хуваарь
- Сургалтын сэтгэгдэл





## Маркус Эппер Монгол салбарын үйл ажиллага хариуцсан

## “Ажилчдаа сургаж, чадавхижуулах нь”

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн хямрал болон бусад хүчин зүйлүүдээс улбаатайгаар бизнес эрхлэгчдэд тавигдах шаардлага тасралтгүй өсөн нэмэгдэж байна. Макро эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран цаашид ч өсөх хандлагатай байна. Мэргэжлийн түвшинд үйл ажиллагаагаа явуулж чадаж буй аж ахуйн нэгж компаниуд л хямралыг даван туулах боломжтой юм.

Мэргэжлийн түвшинд бизнесээ удирдан явуулахад нэг гол хөрөнгө оруулалт нь ажилчдаа сургаж, мэргэшүүлэх явдал. Өрсөлдөөн өсөн нэмэгдэж байгаа өнөө үед чадварлаг боловсон хүчин бол компанийн амжилтын нэг салшгүй хүчин зүйл байдаг. Аливаа компанийн өрсөлдөх чадварыг ажилчдын бүтээмжээр хэмждэг.

Ажилчдыг сургаж, мэргэшүүлэн чадавхижуулах тэднийг дэс дараатайгаар дэмжих, чадавхижуулах системтэй үйл ажиллагааг хэлнэ. Үүнд ажилтны мэргэжлийн мэдлэг чадварыг хөгжүүлэх, тухайн цаг үе болон цаашид хэрхэн ажил үүргээ хийж гүйцэтгэхэд нь шаардагдах ур чадвар эзэмшүүлэхэд нь чиглэсэн бүхий л үйл ажиллагаа хамаарна. Ажилчдаа хөгжүүлснээр залгамж халааг бэлтгэх болон удирдах ажилтныг дэмжих нөхцөл бүрдэнэ. Хүний нөөцийг сургаж, чадавхижуулахын тулд компани төсөв гаргаж, хөрөнгө оруулалт хийдэг тул сургалтыг зорилго, шаардлагад нийцүүлэх нь чухал юм.

Ажилчдаа сургаж, чадавхижуулах нь компанийн хувьд:

- Алсын хараа болон эрхэм зорилгыг мөрдлөг болгох
- Ажилчдын ур чадварыг компанийн явуулж буй үйл ажиллагаатай нийцүүлэх
- Чадварлаг мэргэжлийн боловсон хүчин болон удирдах албан тушаалтны нөөцийг хангах
- Өөрийн компаниас ирээдүй хойч болон залгамж халааг бүрдүүлэх ингэснээр гадаад зах зээлээс хараат байдлыг бууруулах
- Компани зах зээл дэх ажил олгогчийн байр сууриа бэхжүүлэх
- Компани хөгжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой юм.

Харин ажилчдын хувьд хөдөлмөрийн зах зээл дээр өөрийн эзлэх байр сууриа нэмэгдүүлэх давуу талтай. Компанийн хувьд энэ нь нэг талаас сургаж, мэргэшүүлсэн ажилтан нь компанийг орхин гарах магадлал өсөх боловч нөгөө талаас ажилтны хувьд ур чадвараа нэмэгдүүлснээр ажлын байраа баталгаажуулах буюу ирээдүйд мэргэжлээрээ өсөж дэвших суурь болдог. Аж ахуйн нэгж компаниуд ажилчдынхаа ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь тэднийг тогтвор

суурьшилтай ажиллахад нэг түлхэц болдог. Ажилчдаа сургахдаа тэдэнтэй тусгайлан гэрээ байгуулах буюу тохиролцоо хийх тохиолдол түгээмэл байдаг.

Ажилтныг сургаж, чадавхижуулах нь захирлын шийдвэрлэх асуудал байдаг. Захирал нь чадвартай, идэвх зүтгэлтэй ажилчидаа танин мэдэж, мэдлэг чадварыг нь дээшлүүлэх тал дээр арга хэмжээ авч, ахиц дэвшил хир байгаа тал дээр хяналт тавих шаардлагатай. Ажилтан өөрийгөө хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх нь чухал бөгөөд идэвх санаачилгатай, хариуцлага хүлээх чадвартай гэдгээ харуулах шаардлагатай.

Эцсийн дүндээ компанийн гол чиг үүрэг хариуцлага ажилчдаа сургах явдал юм. Мэргэжлийн мэдлэг чадваргүйгээр ямар ч бизнес эрхлэгч бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу үйлчилгээ үзүүлж чадахгүй. Төр ажилчдыг сургаж, чадавхижуулах нөхцлийг нь бүрдүүлж, бодлогоор дэмжиж үүрэгтэй. Ингэхдээ хөдөлмөрийн зах зээл дээр гарах ажиллагсад болон боловсон хүчин мэргэжлийн мэдлэг, ур чадварын хувьд сайтар бэлтгэгдсэн эсэхэд анхаарах, хяналт тавих шаардлагатай. Тэгэхлээр хөдөлмөрийн зах зээл дээр ажил хайж буй мэргэшсэн, чадварлаг ажиллагсадын ашиг тусыг боловсон хүчин хайж буй аж ахуйн нэг компаниуд хүртэнэ гэсэн үг. Нэг ёсондоо ажилтан авахдаа ур чадвар муу байгаа эсэхэд эргэлзэх хэрэггүй болно.

Удирдах ажилтнууд, бизнес эрхлэгчид болон менежерүүдэд зориулсан тусгайлсан сургалтуудыг BPN санал болгодог билээ. Манай сургалтын нэг гол онцлог нь амьдралд ойр бодит мэдлэг олгодогт оршдог.

Бүх бизнес эрхлэгчиддээ ажилчдаа сургаж, мэргэшүүлэх үйлсэд нь амжилт хүсье.





## Ц.Оюунжаргал Стратегийн Зөвлөх ME/MBA/CMCе

*БPN Монгол салбар 2012 оноос хойш Швейцарь зөвлөхийн хорь гаруй үндсэн сургалтууд, бизнес төлөвлөгөө болон санхүү бүртгэлийн дөч орчим зааварчилгаа олгох сургалтуудыг тус тус амжилттай зохион байгуулаад байгаа билээ. Бид сургалтын цар хүрээгээ өргөжүүлж, 2017 оноос дотоодын сургагч багш нартай хамтран ажиллаж байгаа бөгөөд анхны сургалтаа “Борлуулалтын ур чадварыг хөгжүүлэх нь” сэдвийн хүрээнд 2017 оны 5-р сарын 19-20-нд GSMI Институттэй хамтран зохион байгуулсан юм.*

**- БPN Монгол салбартай явуулж буй хамтын ажиллагааны хүрээнд “Борлуулалтын ур чадварыг хөгжүүлэх” нь сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтын талаарх сэтгэгдлээ хуваалцана уу?**

- БPN-ээс анх хамтран ажиллах санал тавихад миний бие баяртайгаар хүлээн авсан. Олон улсын байгууллага Монгол зөвлөх багш надад хамтран ажиллах санал тавина гэдэг бол миний хувьд нэр төрийн хэрэг юм. Түүнээс гадна олон улсын байгууллагуудад олон жил ажилласан миний хувьд БPN-ийн шалгууруудыг давах буюу тэнцээд БPN-ийн харилцагч жижиг, дунд үйлдвэрлэгч Монголын баялаг бүтээгчдэд энэхүү сургалтыг амжилттай явууллаа. Сэтгэгдэл өндөр байгаа.

**- Таны явуулдаг бусад сургалтуудаас БPN-тэй хамтран явуулсан сургалтын онцлог юу байв?**

- Сургалтад маань дандаа дунд болон дээд түвшний менежерүүд, нэлээд олон компанийн захирлууд суусан. Тэр утгаараа сургалтын маань нэг онцлог гэвэл агуулгын хувьд зөвхөн борлуулалтын талаар ярих биш захирлууд, удирдагчид болон гүйцэтгэх захирлуудад чиглэсэн өдөр тутам тэдний алддаг онодог, ялангуяа дутуу харж, бодож болон бас үнэлдэг зүйлүүдийг хэлж өгсөн. Борлуулалтаа сайжруулна гэдэг нь зөвхөн арга техникээ сайжруулах бус цогцоор шийдэх явдал юм. Тухайлбал маркетингаа сайжруулах ажилтнаа

чадавхижуулах зэргээс гадна мөн захирал өөрөө сайн удирдагч, үлгэрлэгч байх ёстой. Сургалтаар менежментийн нэлээд олон арга техникийг оролцогч нартаа зааж өгсөн. Захирлууд маань нэлээд тааламжтай хүлээж авсан. Бас нэг онцлог гэвэл нэлээд хурдтай явагдсанаас гадна, оролцогчиддоо харилцан суралцах боломж олгох арга техникийг түлхүү хэрэглэсэн. БPN-ийн харилцагч бизнес эрхлэгчид маань идэвхтэй, бас нээлттэй, эерэг хүмүүс гэдэг нь надад нэлээд анзаарагдсан.

**- Стратегийн зөвлөх болон сургагч багш хүний өнцгөөс харахад манай жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд ямар чиглэлийн мэдлэг дутмаг байдаг вэ?**

- Би сургалт бүр дээрээ мэдээллийн технологийн ач холбогдлыг хэлж өгдөг. Харамсалтай нь жижиг, дунд бизнесүүд маань энэ тал дээр жаахан хоцрогдож байна. Бид дэлхийн зах зээл дээр өрсөлдөхийн тулд илүү чанартай бас онцлог бүтээгдэхүүн хийх шаардлагатай. Тэгэхлээр би сургалтаараа бизнес эрхлэгчдэд мэдээллийн технологи нэвтрүүлэхгүй, давуу талыг ашиглахгүй байх нь том асуудал гэдгийг ойлгуулахыг их хичээсэн. Шинэ техник технологи нэвтрүүлэхгүйгээр өнөө үед бизнес хийвэл өрсөлдөх чадвараа алдах том аюултай. Хамгийн наад захын хэрэглээний програмуудыг нэвтрүүлэх нь маш чухал.

**- Цаашид хамтын ажиллагааныхаа хүрээнд ямар сургалтууд явуулахаар төлөвлөж байна вэ?**

- БPN-тэй хамтран зохион байгуулах дараагийн сургалт маань татвар, эрхзүйн талаар мэдлэг олгох сургалт байгаа. Бизнес эрхлэгчдийн хувьд энэ тал дээр мэдлэг дутмаг байдаг тул их чухал гэж бодож байна. Цаашдаа бизнес эрхлэгчдийнхээ санал хүсэлтэн дээр тулгуурлаад олон сургалтуудыг БPN-тэйгээр хамтран зохион байгуулна гэж найдаж байна.

Ярилцсан М.Даваажав



# Сургалтуудын хуваарь



## Цагийн менежмент 2017.09.11-09.12 /2 өдөр/

**Агуулга:** Цаг төлөвлөлтийн 10 дүрэм, цаг төлөвлөлтийн чухал хэрэгслүүд болох дэвтэр болон цахим хуанлитай дэлгэрэнгүй танилцаж, тэдгээрийг зөв ашиглах арга барил эзэмшинэ. Мөн сургалтын оролцогч бүр үйл ажиллагаандаа уялдсан хувийн төлөвлөгөө гаргах ба цаашид ажил, амралт чөлөөт цагаа зөв төлөвлөн зохион байгуулж стрессгүй, тэнцвэртэй амьдарснаар амжилт таны гарт ирэх болно.



## Хамт олноо удирдахуй 2017.11.08-11.11 /4 өдөр/

**Агуулга:** Удирдагчийн үндсэн зарчмууд: хариуцлага, мотиваци, бүтээлч сэтгэлгээ, алсын хараа ба зорилго, удирдлагын мэдээлэл боловсруулалт, удирдлагын харилцаа, зөв шийдвэр гаргах, ажилтнуудтай хийх уулзалт, ур чадварын үнэлгээ, хувь хүний зан чанар ба хүнийг таних чадвар, DISG зан чанарын загвар, хувь хүний зан чанарт тохируулан харьцах, хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулж, багаар ажиллах нь гэх мэт.


### МҮОНРТ-ийн нэвтрүүлэгч Ч.Ичинхорлоо:

“BPN-ийн сургалтууд Монголчууд бидэнд амжилт, хөгжилд хүрэх арга зам, аз жаргалтай, утга учиртай амьдрах үндэс мөн ёс зүйн үндэс зэрэг сэдвээр чухал ойлголтуудыг зааж өглөө. Олон хүмүүст амжилтын түлхүүр атгуулсанд баяртай байна. Сургалтад хамрагдсанаар би бизнесийг мэргэжлийн түвшинд хэрхэн удирдан явуулах арга барил мөн санхүүгийн сахилга бат, маркетингийн чухал агуулгатай танилцаж, үнэ цэнэтэй мэдлэг олж авлаа. Сургалт бидэнд өөрчлөлт хийх хэрэгтэй гэдгийг сайтар ойлгууллаа. Багшдаа маш их баярлалаа.”



**Сургалт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай вэб хуудаснаас авна уу.**

[WWW.BPN.MN](http://WWW.BPN.MN)



**Хаяг:** СБД, 8-р хороо, Оюутны 33  
"ТАНАН" төв, 404 тоот

**Утас:** 77113309, 70113309

**Э-шуудан:** [info@bpn.mn](mailto:info@bpn.mn)